

**МОНГОЛ ТӨРИЙН АЛБАН ТҮҮХ БҮТЭЭХ ХХ ЗУУНЫ АНХНЫ
ОРОЛДЛОГО ХИЙГЭЭД НИЙТЛЭГДЭЭГҮЙ НЭГЭН
ЗОХИОЛЫН ТУХАЙД**

Х.МӨНХБАЯР

Товч агуулга: 1934 оны намар хэвлэгдсэн А.Амарын “Монголын товч түүх”, Л.Дэндэвийн “Монголын товч түүх”, Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын “Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх” бүтээлүүд Үндэсний хувьсгалын 13 жилийн ойн баяр наадамтай хамтатган тэмдэглэсэн Бүгд Найрамдах Засгийг байгуулсны 10 жилийн ойн баярт зориулан Улсын баяр наадмынтөв комиссоос монгол төрийн албан түүхийг нэн эртнээс хувьсгалын шинэ үед дэвшиж орсон хүртэлх цагийг хамруулжбүрэн дүүрэн гаргахаар шийдвэрлэсний үр дүн байжээ. Үүний зэрэгцээ монголын түүхэн дэх манжийн эзэрхийллийн үеийн болон Бүгд Найрамдах засгийн түүхийн талаар бичсэнбүтээлүүд нийтлэгдэлгүй үлдсэн юм. Тиймээс энэ удаагийн бэсрэг судалгааны ажилд олон нийтэд хүрч чадаагүй Монголын Бүгд найрамдах засгийн 10 жилийн түүхийн тухай нэгэн баримтыг тодруулахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: Анхдугаар Үндсэн хууль, 1934 он, Түүх зохиох комисс, монголын түүхийн зохиол, Ерөнхий сайд П.Гэндэн

Монгол Улсын анхны Үндсэн хууль баталсан явдлыг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн мандах нарнаар олон түмэнд зарлаж, Бүгд найрамдах засгийг тунхагласан билээ. Тиймээс Үндсэн хуулийн баярыг Бүгд найрамдах засгийг байгуулсны баяр хэмээн нэрийдэж жил бүрийн тогтсон өдөр тэмдэглэж ирсэн байна.

Анх 1925 онд батлагдсан Хүчин үнэлэгчдийн дүрэмд ажил хийлгэхгүй амрах сайн өдрүүдийг заасны дотор Ардын засаг ба ард түмний эрхт улс байгуулагдсаны нэг өдөр багтаж байсан¹ бол 1930 оноос мөрдсөн “БНМАУ-ын хүчнээн үнэлэгчдийн хууль”-аар Бүгд Найрамдах засгийг анх байгуулсан үеийн баярыг 7 сарын 11-ний

¹ Монгол Улсын хөдөлмөрийн хуулиуд (1925, 1930, 1933, 1934, 1941, 1973, 1991, 1999). Эмхэтгэсэн Баасан Л., Болормаа С. Улаанбаатар: 2003, 2.

1 өдөр тэмдэглэж байхаар тогтож², 1933 оны Хүчин үнэлэхүйн тухай хуулинд жил бүрийн 7 дугаар сарын 11-нд тохиох Ардын хувьсгалын ба Ардын хувьсгалт цэрэг хийгээд үндэсний тусгаар тогтносон ба Ардын Бүгд Найрамдах Улсыг байгуулсан зэргийн ойн баяр, мөн Ардын ба цэргийн хийгээд Улсын наадмын 7 өдөр амарч байхаар заажээ³.

Харин 1934 онд тохиосон Бүгд найрамдах засгийг байгуулсны 10 жилийн ойн баярт БНМАУ-ын төр засаг онцгой ач холбогдол өгсөн бөгөөд үүнд Ерөнхий сайд П.Гэндэнгийн нөлөө, хүчин оролцоо ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан БНМАУ-ын төрийн дээд эрх барих байгууллага Улсын Бага Хурлын анхны даргаар 1924-1927 онд ажиллан, Монгол төрийг 3 жил шахам тэргүүлж⁴, Үндсэн хуульт Бүгд Найрамдах Засгийг төлөвшүүлэхийн төлөө хичээн зүтгэж байсныхаа хувьд П.Гэндэн энэхүү баярт анхаарал талбисан нь зайлшгүй юм. Тэгээд ч, 1932-1936 онд тус улсын Ерөнхий сайдаар ажилласан түүний хамгийн эрмэг, зоримог хийгээд нэр хүнд, нөлөөтэй байсан жил 1934 онд Бүгд Найрамдах засгийн 10 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд тэрбээр багагүй нөлөөлсөн нь дамжиггүй.

Ардын Сайд нарын Зөвлөлийн 1933 оны 36 дугаар хурлаар тогтоолын 3 дугаар зүйлд Үндсэн хууль баталж, Бүгд Найрамдах засгийг байгуулсан ойн баярын талаар хэлэлцээд:

“Тус улсын ардын жинхэнэ Бүгд Найрамдах Засгийг байгуулсан 10 жилийн ойн их баяр ирэх 24 он(1934 он)-д болох тул энэхүү их баярыг Улсын 13 жилийн их баяр лугаа хамтатгаж, мөнхүү 7 сард явуулахаар тогтож⁵”, уг баярын ажлыг хэрхэн өргөн бөгөөд чанар төгөлдөрөөр гүйцэтгэх тухай хэргийг зориуд эрхлүүлэхээр Төв комиссыг тусгайлан байгуулжээ.

Улмаар, 1933 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 12 цагт Засгийн газрын байшин дахь Гадаад яамны сайдын тасалгаанд хуралдсан Баяр наадмын Төв комиссын I хурлаар зохион байгуулалтын олон асуудал хэлэлцэхэд, Улсын ба Бүгд Найрамдах Засгийн түүхийн комисс байгуулж, даргад Чойбалсан, гишүүд Элдэв-Очир, Бадрах, Баттөмөр, Ядамсүрэн нарыг баталж, тэдэн дээр Өлзийбат, Дэндэв, Раднаабазар, Остолов, Жамьян нарыг нэмэхээр тогтов⁶.

² Мөн тэнд, 20.

³ Мөн тэнд, 34.

⁴ УТТХСТ. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон (XVIII боть). Улаанбаатар: 2008, 25.

⁵ МУУТА. X 1, Д 2, ХН 522, 17.

⁶ Мөн тэнд, 17, 18.

Түүх зохиох комисс 1933 оны 12 сарын 30-нд анхны хуралдаанаа хийхэд, тус комиссын дарга Х.Чойбалсан:

“Бидний комисс нь Төв комиссын даалгаврын ёсоор эл улсын өргөн их баярт онцоор зориулагдсан түүхийн зохиолтыг гүйцэтгэхдээ эртнээс нааш тус монгол улсын түүхийн буй болж улирч ирсэн байдлаас эхлэн эдүгээх хувьсгалын шинэ үед дэвшиж орсон хүртэлх бүхий л байдлыг чухамхүү үнэн баримт бүхий зүйлийг олон түмэн ардын таньж мэдэх ба сургууль соёлоор оролдогчид болон хэрэглэгчдэд ойлгомжтой бөгөөд үүрдийн үлдээн тэмдэглэх түүхийн чанарт бүрнээ хандуулсан тодорхой томруунаар анги бүлэг болгон алин зохистойгоор зохиох нь чухал” гэж хэлсэн нь комиссын зорилго анхнаасаа Монгол төрийн албан түүхийг бүрнээр бүтээх явдал байсныг илтгэж байна. Тиймээс хурлын тогтоолд:

“Монголын түүхийг зохиохдоо энэ удаа төдий дэвтэрт багтаана хэмээн хэмжээлэх явдалгүй бичиж гүйцсэн даруйд хэдэн дэвтэр болгон хэвлүүлбээс эмхтэй сонирхолтой болж чадах байдалд тохируулан гүйцэтгэвээс зохих учир одоо бүх түүхийн ангийн асуудалд холбогдох зүйлүүдийг 4 үндсэн ангиар хувиарилан тус тусд учрыг бүртгэсэн дэлгэрэнгүй бөгөөд үнэн утга чанартайгаар баримт нөхцлийг бүртгэн шинжлэн бичвээс Монголын эртнээс инагш улирч ирсэн үнэн түүхт байдал илрэн тодрогдож ирэх ба эдүгээ үеийн боловсрол хөгжил хийгээд эцэс хойдод түүх болгон үлдээж хэрэглэхэд хангалттай болгон чадах баймой” хэмээн тэмдэглээд:

Нэгдүгээр ангид

1. Монголын эртнээс инагш хэрхэн оршиж ирсэн үндсэн язгуурын түүхт явдал. Үүнд:

- Бүх монголчууд Чингисээс урьд хэддүгээр зууны үед хэрхэн хөгжиж хэдэн үе хичнээн онд мандаж байгаад юуны учир шалтгаанаас буурч Монгол үндэстэн салалцаж доройтсон тухай;
- Монгол улс манж, хятадад захирагдаж, хольцолдон байсан үед Манжийн захиргаа ба дотоодын лам, ноёдын хэтэрхий хэмжээ эрх, олон түмэн ардыг хэрхэн дарлаж мөлжсөн хийгээд ялангуяа, сүүлийн үед ямар зүйлийн зовлонт байдалд хүргэж тэсвэрлэх бэрх болж, тусгаарлан салалцах сэдэв үүсч ирэх хүртэл тасалбар болгомой.

Үүнийг бичиж гүйцэтгэхэд нөхөр Амарт даалгасугай.

1. Монгол улс Манж хятадын захиргаанаас ямар зорилготойгоор салсан ба автономит засгийг байгуулан улс төрийн эрхийг хэн эзэлж, ямар замаар хөтөлж

⁷ Мөн тэнд, 20-24, 76-80, 81-85 (энд уг хурлын орос орчуулга буй).

ирсэн, улсыг бататган хөгжүүлэх хүч боловсрол байсан эссэн хийгээд сүүл үеийн аймаг шавийн зөрөлдөөн тэмцээн болж, түмэн ардын санал алдагдан түгшүүртэй, хорсолтойн туйлд хүргэж, хятадын харгис гэ мин түшмэл цэргүүдэд хэн тэргүүлж эгүүлэн худалдсан ба барон Унгерныг урин авчирч ямар хор хөнөөлтэй ажлыг явуулж байсан зэргийг цөм он сар баримттайгаар бичиж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүргэж тасалбар болгомуй. Үүнийг бичиж гүйцэтгэхийг нөхөр Бадрах, Дэндэв нарт даалгасугай.

Хоёрдугаар үндсэн ангид

11 дүгээр он(1921 он)-ы Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба хувьсгалын анхдугаар үеийн байдал. Үүнд: энэхүү хятадын харгис гэ мин түшмэл цэргүүд ба барон Унгернын эзэрхэн түйвээсэн, Монголын газар шороо зовлонт ард түмний төлөө хэн тэргүүлж аль газрын тусламжийг олж, тэр үеийн түгшүүртэй байдлыг тийм түргэн баатарлагаар ялж туулан, Ардын Түр Засгийг байгуулахад ямар учир шалтгаанаас хэмжээт эрхт хант засгийг явуулсан. Мөн засаг төрийн хуучин харгис явууллагыг хэрхэн өөрчлөн засаж, ард түмэнд эрх чөлөө олгосон энэ тухай хэн тэргүүлж хувьсгалд эсэргүүцэж гарсныг яахин дарж сөнөөсөн зэргийн үе дараалж ирсэн явдлууд болон мөн хувьсгалын ажил хөгжсөн үнэн хүчит байдал зэргийг тус тус болж байсан он сар өдөр зэргийг тодорхойлон бүртгэж, Бүгд Найрамдах Засгийг байгуулсан үе хүргэж, тасалбар болгох учир эл үндсэн хөдөлгөөний түүхэнд тэргүүлэн манлайлж онц хүчин болон оршиж удирдсан хувьсгалт нам ба эвлэл, улаан цэргийн түүхийг дэс дараалан уялдуулж тодорхой баримттайгаар бичмүй. Иймд:

1. Үндэсний хөдөлгөөний ерөнхий байдлыг нөхөр Дэмид, Чойбалсан, Лосол
2. Намын түүх зохиоход нөхөр Элдэв-Очир, Лувсаншарав нар
3. Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн түүхийг нөхөр Мэнд
4. Ардын үндэсний хувьсгалт улаан цэргийн түүхийг нөхөр Дэмид
5. Улсын Дотоодыг Хамгаалах Газрын түүхийг нөхөр Намсрай эдгээр нөхдийг тус тус томилон даалгасугай.

Гуравдугаар үндсэн ангид

Бүгд найрамдах засгийг байгуулсан ба 10 жилийн дотор явж ирсэн нь:

1. Бүгд Найрамдах Засгийг байгуулж, Үндсэн хуулийг баталсан тухайг тайлбарлан бичих ба түүнээс хойш 10 жилийн доторх хувьсгалын ажлын

онц онц ололт бүтээлтүүд хийгээд энэ завсар тохиолдож гарсан эсэргүү ангиудыг хэрхэн дарж сөнөөсөн ба одоо чухамхүү ямар учир шалтгаанаас Шинэ эргэлтийг гаргаж, эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн шинэ маягийн баячуудын ардчилсан үндэсний Бүгд Найрамдах Засгийн шинжтэйгээр тогтнон буй ба элдэв ажлыг Монгол орны онцгой байдалд нийлүүлэн явуулсан зэргийг цөм дэлгэрэнгүйгээр бичиж гүйцэтгэхийг нөхөр Гэндэнд

2. Монголын Үйлдвэрчний эвлэл юуны учир буй болсон, малчин ардад ямар ашиг тус хүргэх зорилготой болохыг бүртгэн бичмүй. Үүнийг бичиж гүйцэтгэхийг нөхөр Яндагт тус тус томилж даалгасугай.

Дөрөвдүгээр ангид

Бусад засгийн олон байгууллагууд ба аж ахуйн хийгээд олон нийтийн газруудын тухай. Үүнд:

1. Эдгээр олон байгууллагуудад эрхлэх 1. Мал ажил, 2. Санхүү, 3. Худалдаа үйлдвэр, 4. Зам тээвэр 5. Аж үйлдвэр ба гар үйлдвэр 6. Төв коопертив 7. Ардыг гэгээрүүлэх явдал 8. Ардын эрүүлийг хамгаалах явдал 9. Шинжлэх ухааны явдал, 10. Шүүх таслахын байгуулалтууд энэ 10 жилийн дотор хэрхэн хөгжиж чадсан ба хойшид хэрхэн хөгжиж уг зорилгыг дүүрэн хангалттай болох зэргийг тодорхой томруулаар бичиж гүйцэтгэхээс гадна мөн орон нутгийн захиргаа ба олон аймгийн яамдын байгууллагууд ажил явууллагыг эрхбиш энэхүү ангид уялдуулан бичиж гүйцэтгэхийг зорьмуй. Эдгээр зүйлийг тус тусын яамны сайд дарга эрхлэгчдийн зэрэг хүмүүст даалган өгч гүйцэтгүүлэх явдлыг комиссын дарга Чойбалсан, гишүүн Баттөмөр нараас эрхлэн гүйцэтгэмүй⁸” гэж тус тус заажээ.

Улмаар бичих зүйлүүдийг 1934 оны 4 дүгээр сарын 1 хүртэл багтаан төгсгөх бодлоготойгоор зохиож байгуулаад 5 дугаар сарын 1-ний өдөр гэхэд уг материалуудыг хянан үзэж, элдэв талаар засан залруулж, 6 дугаар сарын 1-ний өдрөөс урьд Хэвлэлийн хороонд хэвлүүлэхээр өргөж, мөн сард багтаан уул хураамжилсан дэвтрийг хэвлэн гаргуулахаар тогтжээ.

Түүнчлэн, хувьсгалд идэвхитэйгээр оролцож явсан ба улсын ба улс төрийн явдалд зүтгэгчдийн биеийн зураг бүхий альбомыг тэдний товч биограф хэмээх түүхийн хамт зохион гүйцэтгэх, хувьсгалд идэвхитэйгээр оролцож явсан ба улсын ба улс төрийн явдалд зүтгэгчид нараас сонинууд ба түүхийн зүйлд гаргахаар

⁸ Мөн тэнд, 20-24, 76-80, 81-85.

хувьсгалын тухай ба Бүгд Найрамдах улс байгуулсан зүйлийг өөр өөрийн үзэмжээр бичиж ирүүлэхийг хүсч захидал явуулах, Ойн баяр хүртэл түүхийн музейд зохих материалуудыг бүртгүүлэн цуглуулж тавих зэрэг цөөнгүй ажлыг зохиохоор болсон аж.

Түүний хойно 1934 оны 2 дугаар сарын 2-нд хуралдсан Ардын Сайд нарын Зөвлөлийн 3 дугаар хурлаас Их баярт зориулан гаргах түүхийн зохиолтын энэхүү төлөвлөгөөг ном хэвлэх зардал 70.000 төгрөгийн төсвийн⁹ хамтаар баталжээ¹⁰.

Түүхийн комиссын үйл ажиллагааг багцалбал, Улсын болон Бүгд Найрамдах Засгийн ойн баярын хүрээнд:

1. Төрийн албан түүх
2. Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн газруудын түүх
3. Улс төрийн зүтгэлтнүүдийн гэрэл зургийн цомог бүтээх зорилготой байсан нь мэдэгдэж байна.

Ерөнхий сайд П.Гэндэнгийн хувьд нэн эртнээс 1934 оныг хүртэлх үеийг хамарсан монгол Төрийн албан түүх бүтээх эл үйлст өөрийн үүрэгтэйгээр оролцжээ. Тодруулбал:

- I. Нэн эртнээс улс төрийн бутралын хамруулан Амар
- II. Манжийн эзэрхийлэлд орсон үеийг Амар
- III. Автономит засгийн тухайд Дэндэв
- IV. 1921 оны хувьсгалын ялалт, үр дүнгийн тухай асуудлыг Х.Чойбалсан тэргүүтэй хүмүүс эрхлэн хариуцаж байсан.
- V. Харин П.Гэндэнгийн хувьд тухайн цагийн Монгол төрийн залуу үе: Анхдугаар Үндсэн хууль баталж, Бүгд Найрамдах засгийг тунхагласнаас хойшхи 10 жилийн төрийн түүхийг нягтлан боловсруулах үүрэг хүлээжээ.

Гэвч Түүхийн комиссын төлөвлөгөөт ажлууд нь хэдхэн сарын дотор амжуулахуйц хялбархан зүйл биш болох нь алсдаа мэдэгдсэн аж.

Үүнийг Төв комиссын дарга Х.Чойбалсангаас 1934 оны 6 дугаар сард Ардын Сайд нарын Зөвлөлд хүргүүлсэн илтгэл баталдаг¹¹. Энэхүү өдөрлөөгүй илтгэлд:

“Хувьсгалт нам, Улаан цэргийн хийгээд Дотоодыг Хамгаалах Газрын түүхийг бичиж ирээгүй, Эрүүлийг Хамгаалах Яам ба Үйлдвэрчний Эвлэл, Шинжлэх Ухааны Хүрээлэн зэргээс тус тусын энэхүү 10 жилийн доторх түүхийг бичиж ирсэн. Бусад олон яамуудын зэрэг газраас түүхийг бичиж ирээгүй тул шаардан

⁹ Мөн тэнд, 8.

¹⁰ Мөн тэнд, 200.

¹¹ Мөн тэнд, 9, 31-40.

авч өөр хянан гүйцэтгэнэ¹²” гэж тэмдэглэсэн нь буй.

Тиймээс 1934 оны 6 сарын 21-ний өдрийн пүрэв гарагийн оройн 4 цагт Мал Тариалангийн Яамны сайдын өрөөнд хуралдсан Төв комиссын 4-р хурлаар¹³ түүх зохиох ажлын явцыг хэлэлцэн тухайлан тогтоол гаргажээ. Эл тогтоолд:

1. “Ерөнхий сайд Гэндэнгээс Ардын үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд Найрамдах Засгийг байгуулж, Үндсэн хуулийг баталсан 10 жилийн ойд зориулж бичсэн зүйл ерөнхийд зүйтэй болсныг баталж, энэхүү зүйлд Элдэв-Очироос нэмэн оруулах хэмээсэн саналыг гаргуулан авч, тусгай хуралдан хэлэлцэх явдалгүй, комиссын гишүүдэд хэсүүлэн үзүүлж, нэмэн оруулж хэвлэх эсэхийг тогтон, даруйхан хэвлүүлэх;
2. Нөхөр Дэмид, Чойбалсан нараас зохион төлөвлөсөн Монгол Ардын Үндэсний хувьсгалын хөдөлгөөний тухай товч түүхийг ерөнхийд зүйтэй болсон тул баталж, гагцхүү оршилд нэмэх зүйл буй эсэхэд бусад нөхдийн саналыг авч, нэмэн оруулах зэргээр даруйхан хэвлүүлэх;
3. Дэмид, Чойбалсан, Гэндэн нараас бичиж гүйцсэн, Амар, Дэндэв нараас гүйцэхийг шахамдан буй 4 анги түүхийн зохиолыг хэдэн хувь хэвлүүлэх тухай Чойбалсангийн асуултыг хэлэлцээд дууссан 2 зүйлийг наадмын урьд эрхэтгүй гаргах ба хэвлүүлэхэд сайн цаасан дээр 16-т үсгээр зардалд тохируулан тус бүр 5.000 хувь хэвлүүлэх¹⁴”-ээр заасан байна.

Ерөнхий сайд П.Гэндэнгийн 1934 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 69 тоот тушаалаар Төв комиссын энэхүү тогтоолыг баталсан ажээ¹⁵.

Баримтаас үзэхэд, ХХ зууны монгол төрийн анхны албан түүхийн бүрдэлд орсон бүтээлүүд Улсын ба Бүгд Найрамдах Засгийн ойн баяр наадмын өмнө хараахан нийтлэгдэж амжаагүй, харин 1934 оны 9 дүгээр сарын эхээр хэвлэлд шилжиж, хэвлэлтийн янз бүрийн шатанд байсан бөгөөд Дэмид, Чойбалсан, Лосол нарын зохиосон “Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх” ном дөнгөж хэвлэлтээс гарч, Амарын “Монголын товч түүх” зохиолыг хэвлэн дэвтэрлэж, Дэндэвийн “Монголын товч түүх” бүтээлийг хянан магадлаж байв.

Харин А.Амарын бичиж байсан манжийн үеийн монголын түүх, Ерөнхий сайд П.Гэндэнгийн эрхэлж байсан Бүгд Найрамдах Засгийг байгуулж, Үндсэн Хуулийг баталсан 10 жилийн түүх нийтлэгдсэнгүй төдийгүй хэрхсэн нь тодорхойгүй чимээ алдарчээ.

¹² Мөн тэнд, 40.

¹³ Мөн тэнд, 4.

¹⁴ Мөн тэнд, 2, 3.

¹⁵ Мөн тэнд, 28.

Судалгааны явцад дээрх асуултад хариу өгөх сэжүүр илэрсэнгүй. Гэвч архивын баримт сэлтийг нягтласан ажлын дүнд мэдэгдсэн, Монгол Улсын Үндэсний Төв Архивын Орчин үеийн түүхийн баримтын сангийн “Хөмрөг-1, Данс-6, Хадгаламжийн Нэгж-309” товъёогтбуй “Улсын 13 жилийн ой, Үндсэн хууль баталсны 10 жилийн ойд зориулсан Гэндэнгээс тавьсан илтгэл” хэмээх баримтыг П.Гэндэнгийн хариуцаж байсан холбогдох зохиолын гар бичмэлхэмээн үзэж байна. А4 цаастай ойролцоо хэмжээ бүхий дөрвөлжин шугамтай зузаавтар цаасны нэг талд балын харандаагаар голлон бичиж, гурван ч хэсэгт бичгийн машинаар цохьсон оруулгатай, нийт 78 хуудас бүхий энэхүү баримтын агуулгыг шинжлэхэд бидний таамаглал магадтай болох нь тодорлоо.

Архивын баримтын бүртгэл дансанд “Улсын 13 жилийн ой, Үндсэн хууль баталсны 10 жилийн ойд зориулсан Гэндэнгээс тавьсан илтгэл” гэдэг нэрээр тэмдэглэгдсэн эл баримтын нүүрийг сөхөн үзвэл “1934 он. Ардын хувьсгалын 13 жилийн ой, Бүгд Найрамдах Улсыг байгуулж, Үндсэн хуулийг баталсны 10 жилийн ойд зориулан Ерөнхий сайд Гэндэнгээс бичсэн зүйл” гэсэн нэрийг хөх бэхээртавьсан нь харагдана. Түүний арын хуудсанд “Ардын Үндэсний хувьсгал ба Ардын хувьсгалт засгийг байгуулсны 13 жилийн ой ба Бүгд Найрамдах засгийг байгуулж, Үндсэн хуулийг баталсны 10 жилийн ойд зориулав. Гэндэн” гэсэн нэр бас бичигджээ. Энэ удаад хар өнгийн бэхээр тодхон тэмдэглэжээ. Бичгийн хэв, гарын үсэг зэргээс үзэхэд сүүлийн нэрийг ерөнхий сайд П.Гэндэн өөрийн гараар бичсэн нь эргэлзээгүй байна. БНМАУ-д 1940-өөд оны эхэн үеэс Григорийн он тооллыг хэрэглэх болсон учир “1934” гэсэн огноо хийгээд Ардын хувьсгал гэдэг үг бичсэн явдал эхний гарчгийг хожим 1940 оноос хойш өөр хүн бичсэнийг харуулж байна.

Өгүүлэн буй эх бол энгийн нэгэн илтгэл бус, харин Түүх зохиох комиссын даалгавраар П.Гэндэнгийн бичсэн монголын Бүгд Найрамдах засгийн 10 жилийн түүхийн зохиол болохыг түүний гарын үсэгтэй хуудасны ард буй гарчиг илэрхийлнэ. Гарчигт ийнхүү тэмдэглэжээ. Энэхүү зохиолд бичигдсэн зүйлийн гарчиг

Нэгдүгээр бүлэг. Ардын үндэсний хувьсгалын анхдугаар үе. Үүнд:

1. Ардын эрхт хэмжээт цаазат засгийн тухай
2. СССР лугаа харилцаа байгуулсан тухай
3. Анхдугаар үед харъяат улсын байдлыг шинэчлэн өөрчлөх талаар юу хийсэн бэ?

Хоёрдугаар бүлэг. Үндэсний хувьсгалын хоёрдугаар үеийн тухай. Үүнд:

1. Бүгд Найрамдах засгийг байгуулсан тухай
2. Улсын анхдугаар хурлаас хойш одоо хүртэл гарч байсан хувьсгалын эсэргүү нарын тэмцлүүд
3. Улсын 5 дугаар их хурлын тухай ба намын ерөнхий журам, засгийн зорилтыг гуйвуулсан барууны улс төрийн аюулын аюул хэлбэрлүүд хэрхэн үүсч гарсан ба түүнийг хэрхэн буруушаан устгасан тухай
4. Улсын 5 дугаар хурлаас хойш 6 дугаар хурал хүртэл гарч ирсэн хувьсгалын эсэргүү нарын тэмцлүүд
5. Улсын 6 дугаар их хурлын тухай ба Зүүний нугалаа хэрхэн үүсч гарсан ба хэрхэн дарж устган, Шинэ эргэлтийг гаргасан тухай
6. Улсын 18 дугаар Бага хурлаас тавьсан зорилт ба цаашид гүйцэтгэх үүргүүд
7. Төгсгөлийн ангиг¹⁶ гэжээ.

Зохиолын үндсэн хэсгийн эхэнд “Ардын үндэсний хувьсгалт засаг байгуулсны 13 жилийн ой ба Бүгд Найрамдах засгийг байгуулж, Үндсэн хуулийг баталсны 10 жилийн ойд зориулъя” хэмээн тэмдэглэсэн байна.

Төгсгөл

Түүхийн баримтыг мөшгин үзэхэд, Монгол төрийн албан түүхийг бүтээх XX зууны анхны оролдлого ЗХУ-ын Шинжлэх Ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академийн хамтын бүтээл гэсэн тодорхойлолттойгоор 1954 онд Москвад оросоор, 1955 онд Улаанбаатарт монгол хэлээр анх нийтэлсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх¹⁷” бүтээлээс даруй хориод жилийн урьд эхэлсэн байна.

Үнэн хэрэгтээ, эдүгээ ч хоорондоо уялдаагүй, анги тусгаар, мэтээр ойлгогдсоор буй А.Амарын “Монголын товч түүх”, Л.Дэндэвийн “Монголын товч түүх”, Х.Чойбалсан, Г.Дэмид, Д.Лосол нарын зохиосон “Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх” бүтээлүүд нь 1934 онд Үндэсний ардчилсан хувьсгалын ба Ардын хувьсгалт үндэсний улаан цэргийн 13 жилийн ой хийгээд Бүгд Найрамдах Засгийг байгуулсан 10 жилийн ойн их баярыг ёслон тэмдэглэх ажлын хүрээнд бүтээгдсэн Төрийн албан түүх, иж бүрэн цуврал ажээ.

Монгол төрийн дархан түшээ, бичгийн их хүмүүн А.Амар абугай Шинжлэх Ухааны хүрээлэнгийн даргаар томилогдон, 1930-1932 онд тус улсын шинжлэх ухааны хэргийг тэргүүлж байхдаа Монголын түүхийг нэн эртнээс тухайн үе хүртэлх

¹⁶ МУУТА. X 1, Д 6, ХН 309, 3.

¹⁷ 1966, 1984 онуудад энэ зохиолын монгол хэл дээрх хувилбарын 2, 3 дугаар хэвлэлт гарсан болно.

хугацааг хамруулан туурвихаар шийдвэрлэж, хэд хэдэн цуврал бүтээл хэвлүүлэхээр бэлтгэсний үр дүн¹⁸ нь 1934 онд хэвлэгдсэн Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын зохиол “Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх”, А.Амарын “Монголын товч түүх”, Л.Дэндэвийн “Монголын товч түүх” бүтээл, хараахан нийтлэгдэж амжаагүй А.Амар, П.Гэндэн нарын бусад зохиолууд юм.

1927 оны үесээс үндэстэй улсын түүх бүтээх ажлын хүрээнд Төрийн түүх, Цэргийн түүх, МАН-ын түүх, МХЗЭ-ийн түүх гэсэн 4 чиглэлээр түүх бичих судалгаа эхэлж, тус бүрээр бүтээл гарсан нь Төрийн албан түүхийг бүтээх гэсэн 1934 оны үйлст ихээхэн дөхөм үзүүлсэн гэдгийг дашрамд онцгойлон өгүүлэх нь зүйтэй.

Энэхүү бэсрэг судалгааны ажлын үр дүнд доорх зүйлүүдийг онцолж болохоор байна.

1. Төрийн албан түүх бүтээх анхны оролдлогыг 1927-1931 оны үест эхлүүлсний үр дүнд Бүгд Найрамдах Засгийг байгуулсны 10 жилийн ойн хүрээнд Монголын түүхийг нэн эртнээс 1924 он хүртэл өгүүлсэн цувралууд хэвлэгдсэн.
2. Эл оролдлогын явцад бүтээгдсэн А.Амарын манжийн үеийн түүхийг өгүүлсэн зохиол, П.Гэндэнгийн Бүгд Найрамдах Улсын 10 жилийн түүхийн тухай бүтээл хараахан нийтлэгдэж амжаагүй ажээ. Түүний дотор П.Гэндэнгийн зохиолын гар бичмэл архивт хадгалагдсаар байна.
3. Нийтлэгдсэн бүтээлүүдодоо ч үнэ цэнэтэй хэвээр буй учир Монголын Бүгд Найрамдах төрийн 10 жилийн түүхийн талаарх П.Гэндэнгийн зохиолыг нийтэд түгээн танилцуулах нь ач холбогдолтой нь эргэлзээгүй.

1920-иод оны сүүлчээр үндэсний сэхээнлэг зүтгэлтнүүдийн санаачлан эхлүүлж, 1930 оны эхээр Шинжлэх Ухааны хүрээлэнгийн дарга А.Амарын үргэлжүүлсэн Монгол төрийн албан түүхийг бүтээх XX зууны анхны оролдлогод Ерөнхий сайд П.Гэндэн түүхэн бие хүний хувьд төдийгүй зохиогч, бүтээгчийн оролцсоныг түүхийн баримт гэрчилж байна.

П.Гэндэнгийн бичсэн БНМАУ-ын 10 жилийн түүхэн замналын тухай түүх бичлэгийн баримтыг эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулж, олон нийтэд түгээн сурталчлах нь шинжлэх ухааны ач холбогдолтойгоос гадна ороо бусгаа

¹⁸ Чойбалсан Х., Лосол Д., Дэмид Г. Монгол Ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх [Монголын эх түүх: Боть YI].Эмхэтгэсэн Харнууд З.Лонжид, Эмгэнт О.Батсайхан. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2014, 9.

цагийн эрхээр төрийн хавчлагад өртсөн түүний нэр төрийг сэргээн сурталчилж, дурсгалыг мөнхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болно гэдгийг эцэст илэрхийлье.

Abstract: In 1934, Mongolians celebrated the 10th anniversary of the Republican governance combined with the National Holiday-Naadam. Then, the National Holiday's organizing commission ordered the writing of an official history of the Mongol state by A.Amar, L.Dendev, Kh.Choibalsan, D.Losol, and G.Demid etc. At the time when their famous books about the history of Mongolians were published. But, some books about era of the Mongolia under Qing rule or the Republican governance in Mongolia were not published. Therefore, we studied the unknown history of the Republican governance. As a result of our study, we discovered that Prime Minister P.Genden was responsible for writing on this subject. Also, we learnt for the first time, that this important handwriting document (book) is preserved in the National Archives of Mongolia.